



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/337

Өмнөдэлгэр сум


Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өмнөдэлгэр сумын “Оны шилдэг” шалгаруулах журмыг 1 дүгээр, шагналд нэр дэвшүүлэх анкетын маягтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү журмын шаардлага хангасан материалыг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлэхийг албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч, багийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Баярмаа)-д даалгасугай.



Р.ЭНХТӨР

2325310568

D:\disk\bichig hereg/ zahiramj/

сумын Засаг даргын 2025 оны
12 дугаар сарын 08-ны өдрийн
А/337 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



**ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН
“ОНЫ ШИЛДЭГ”-ИЙГ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

Нэг. ЗОРИЛГО

1.1. Тухайн онд эрхэлсэн ажил үүргээ амжилттай биелүүлж өмнөө тавьсан зорилгодоо хүрч, орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан хүүхэд, залуус, малчин, салбар бүрийн төрийн албан хаагч, шилдэг байгууллага, аж ахуйн нэгж, хөдөлмөр эрхлэгч иргэний хийж гүйцэтгэсэн ажлыг үнэлж нийтийн хүртээл болгож алдаршуулах.

Хоёр. ШАЛГАРУУЛАХ ХУГАЦАА ҮЕ ШАТ ХУГАЦАА

2.1. Баг, байгууллага, аж ахуйн нэгж, иргэд хамт олны эхний шатны шалгаруулалтыг явуулж оны шилдгийн шалгуур хангасан 1-ээс доошгүй хүний тодорхойлолтыг 12-р сарын 20-ны дотор ЗДТГазарт ирүүлнэ.

Гурав. ХАМРАХ ХҮРЭЭ:

3.1. Сумын төрийн байгууллага болон аж ахуйн нэгж, албан хаагч, иргэд, хүүхэд залуучууд.

Дөрөв. ОНЫ ШИЛДЭГ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Оны шилдэг хүүхэд:

- Улс, аймгийн олимпиад, уралдаан тэмцээнд сум, орон нутгаа төлөөлж амжилттай оролцсон байх.
- Анги хамт олны дунд нэр хүндтэй төлөвшилтэй, сахилга баттай, хамт олноо манлайлагч байх.
- Сурагчдын өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг дэмжин оролцдог байх.
- Сурах арга барил эзэмшсэн байх.
- Хүмүүнлэгийн аянд оролцдог байх.

4.2. Оны шилдэг залуу:

- Өмнөдэлгэр сумын харъяат 18-35 насны залуу байх.
- Төрөлх нутгийнхаа хөгжил дэвшилд тодорхой хувь нэмэр оруулж, сайн үйлсийн аян зохион байгуулдаг, оролцдог байх.
- Өөрийн ажиллаж буй салбартаа өөрийн авьяас билэг, оюун ухаанаа дайчлан бусдыгаа манлайлан, сум орон нутгаас зохион байгуулсан ажилд идэвх санаачилгатай,
- Тэргүүний манлайлагч залуу байна.

4.3. Оны шилдэг малчин:

- Мал аж ахуйн салбарт ажиллан нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлж, бэлчээрийг зүй зохистой ашигладаг байх.
- Иргэдийг болон туслах малчдаа малжуулсан байх.
- Ахмад малчдын мал маллагааны шилдэг арга туршлагыг үр хүүхэд, туслах малчдадаа заан сургасан байх.
- Мал аж ахуй дээр тогтвор суурьшилтай ажиллаж малаа малладаг байх.

- Багийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж, нийгмийн хариуцлагын хүрээнд хандив тусламж өгсөн байх.

4.4. Оны шилдэг төрийн тусгай болон захиргааны албан хаагч:

- Тухайн жилийн ажлын үзүүлэлтээрээ А үнэлгээ авсан байх.
- Төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйл, төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийг чанд мөрдөн ажилладаг байх.
- Өөрийн эрхэлсэн ажилдаа онцгой амжилт гаргасан байх.
- Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэдэг байх.
- Ажлын бүтээмжийг үе шаттай сайжруулахад идэвх санаачилагатай ажилладаг байх.
- Сум орон нутгаас зохион байгуулсан ажилд идэвх санаачлага гарган оролцдог байх.
- Багаар ажиллах чадвартай байх.
- Тэргүүний төрийн албан хаагч байх.

4.5. Оны шилдэг боловсролын салбарын албан хаагч:

- Тухайн жилийн ажлын үзүүлэлтээрээ А үнэлгээ авсан байх.
- Төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйл, төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийг чанд мөрдөн ажилладаг байх.
- Боловсролын салбартаа амжилт гаргаж, үр дүнд хүрсэн байх.
- Боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулахад идэвх санаачилагатай ажилладаг байх.
- Сум орон нутгаас зохион байгуулсан ажилд идэвх санаачлага гарган оролцдог байх.
- Багаар ажиллах чадвартай байх.

4.6. Оны шилдэг эрүүл мэндийн салбарын албан хаагч:

- Тухайн жилийн ажлын үзүүлэлтээрээ А үнэлгээ авсан байх.
- Төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн, төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийг чанд мөрдөн ажилладаг байх.
- Эрүүл мэндийн салбартаа амжилт гаргаж, үр дүнд хүрсэн байх.
- Ажлын бүтээмжийг үе шаттай сайжруулахад идэвх санаачилагатай ажилладаг байх.
- Сум орон нутгаас зохион байгуулсан ажилд идэвх санаачлага гарган оролцдог байх.
- Багаар ажиллах чадвартай байх.

4.7. Оны шилдэг төрийн үйлчилгээний албан хаагч: /Эрүүл мэнд, боловсролоос бусад/

- Тухайн жилийн ажлын үзүүлэлтээрээ А үнэлгээ авсан байх.
- Төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйл, төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийг чанд мөрдөн ажилладаг байх.
- Тухайн салбартаа амжилт гаргаж, үр дүнд хүрсэн байх.
- Ажлын бүтээмжийг үе шаттай сайжруулахад идэвх санаачилагатай ажилладаг байх.
- Сум орон нутгаас зохион байгуулсан ажилд идэвх санаачлага гарган оролцдог байх.
- Багаар ажиллах чадвартай байх.

4.8. Оны урлаг, спортын шилдэг:

- Урлаг, спортын салбарт амжилт гаргасан байх.
- Олон улсын болон улсын бүсийн чанартай уралдаан тэмцээнд оролцож тухайн жилдээ амжилт гаргасан байх.

4.9. Оны шилдэг байгууллага:

- Байгууллагын үйл ажиллагаа нь жигд тогтмолжсон, иргэдээс ирсэн өргөдөл, гомдолгүй байх.
- Байгууллагын үйлчилгээний стандартаа мөрддөг байх.
- Бүх нийтийн үйл ажиллагаанд байгууллага хамт олноороо идэвхтэй оролцдог байх.
- Төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүртээмжтэйгээр хүргэдэг байх.
- Сум орон нутгийн бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулдаг байх.

4.10. Оны шилдэг баг

- Багийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлт, иргэдэд тайлан мэдээллээ танилцуулсан байдал.
- Мал сүргээ мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан байдал.
- Өвөлжилтийн бэлтгэл хангасан байдал /багийн аюулгүйн фонд, хужир, шүү бэлтгэх/
- Татварын хуулийн дагуу багийн иргэдийн бүх төрлийн татвар төлөлт
- Графикт мэдээ, тайланг хугацаанд нь өгсөн байдал
- Багийн иргэдийн дунд урлаг, спортын уралдаан тэмцээн, өдөрлөг уулзалт зохион байгуулсан байдал, үр дүн
- Багийн дотоод ажил тогтмолжиж, үйл ажиллагаа явуулах багийн сантай байх.
- Багийн хэмжээнд гал түймэр гараагүй байх.
- Багийн тохижилт
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулсан байдал.
- Багийн иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүргэсэн байдал.

4.11. Оны шилдэг аж ахуй нэгж

- Аж ахуйн нэгжийн хувьд үйл ажиллагаа нь тогтворжсон байх.
- Төрийн байгууллагуудтай хамтран үйл ажиллагаа явуулдаг байх.
- Зөв үлгэр дуурайлал үзүүлдэг, бүтээлч, найрсаг хамт олонтой байх.
- Олон нийтийн үйл ажиллагаанд хамт олноороо оролцдог байх.
- Татварын өр төлбөргүй, төлсөн татварын хэмжээ нь жил дараалан өссөн байх.
- Нийгмийн даатгалын зөрчилгүй байх.
- Сумын бүтээн байгуулалт, тохижилтод дорвитой хувь нэмрээ оруулж, байгууллага, орчноо үлгэр жишээ тохижуулсан байх.
- Нийгмийн хариуцлагыг өндөржүүлж, ажлын байрны тоог нэмэгдүүлсэн байх,
- Үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээндээ хэрэглэгчийг дээдлэх зарчмыг нэвтрүүлж, олон нийтийн таашаалыг хүлээсэн байна.

4.12. Оны шилдэг хувиараа хөдөлмөр эрхлэгч:

- Сум орон нутагтаа өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг байх.
- Шинийг санаачилж тууштай хөдөлмөрлөдөг байх.
- Сайн үйлсийн аянд оролцдог байх.
- Ажлын арга барилаараа бусдыгаа манлайлж, орон нутгийн хөгжил дэвшлийн төлөө бусадтай хамтран идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа, сум орон нутгаас зохион байгуулсан өдөрдөг арга хэмжээ, үзэсгэлэн худалдаанд идэвх санаачилга гарган оролцдог тэргүүний баялаг бүтээгч байна.

4.13. Оны шилдэг иргэний нийгмийн байгууллага

- Үйл ажиллагаа нь тогтмолжсон байх

- Төрийн байгууллагуудтай хамтран үйл ажиллагаа явуулдаг байх
- Зөв үлгэр дуурайлал үзүүлдэг, бүтээлч, найрсаг хамт олон байх
- Сайн дурын ажилтнуудын оролцоо, хандивлагчдын тоо
- Иргэдийн идэвхийг нэмэгдүүлсэн байдал
- Нийгэмд үлгэр жишээ болсон сайн туршлага нэвтрүүлсэн байх

Тав. ШАГНАЛД ТОДОРХОЙЛОХОД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

5.1. Шагнуулахаар нэр дэвшүүлсэн хүмүүсийг тодорхойлохдоо дор дурьдсан материалыг бүрдүүлнэ.

5.1.1. Энэ журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан загварын анкет /гэрэл зураг 3х4 хэмжээтэй/

5.1.2. Хамт олны хурлын тэмдэглэл

5.1.3. Ажил байдлын тодорхойлолт

5.1.4. Шагнуулах тухай эрх бүхий албан тушаалтны гарын үсэгтэй албан бичиг

5.1.5. Салбартаа онцгой амжилт гаргасан бол түүнийг гэрчлэх баримт бичиг.

5.1.6. Байгууллагын хувьд А4 хэмжээтэй хамт олны зураг хавсаргасан байх.

5.1.7. Шагналд нэр дэвшсэн хүний ажил байдлын тодорхойлолт нь үнэн зөв, ажлын амжилт, авьяас чадвар, оруулсан хувь нэмрийг товч, тодорхой бичсэн байх бөгөөд холбогдох баримтыг хавсаргасан байх.

Зургаа. ШАГНАЛЫГ ШИЙДВЭРЛЭХ

6.1. Оны шилдэгт баг, байгууллагаас нэр дэвшсэн хүмүүсийн материалыг файлаар болон цаасаар жил болгоны 12-р сарын 20-ны дотор Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэнд ирүүлэх.


6.2. Нийгмийн бодлогын мэргэжилтэн нь энэ журмын дагуу материалаа бүрдүүлж ирүүлсэн иргэдийн талаар саналыг Засаг даргын зөвлөлд танилцуулна.

6.3. Оны шилдэг ажилтанг батламж, мөнгөн шагналаар тус тус шагнана.

6.4. Шилдэг ажилтан, байгууллагаар шалгарсан хувь хүн, байгууллагад урьдчилан мэдэгдэж сумын төв шинэ жилийн арга хэмжээн дээр шагналыг гардуулан өгнө.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

сумын Засаг даргын 2025 оны
12 дугаар сарын 08-ны өдрийн
А/337 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ОНЫ ШИЛДЭГ
..... НОМИНАЦИД НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ

1. Овог, эцэг /эх/-ийн болон өөрийн нэр
2. Төрсөн он сар
3. Хүйс
4. Одоогийн харъяалал
5. Боловсрол, мэргэжил
6. Үндсэн захиргаа
7. Ажилладаг салбар
8. Урьд болон одоо ажиллаж байгаа газар

№	Ажлын газрын нэр	Эрхэлсэн ажил	Хугацаа

9. Төр, Засгийн болон бусад ямар шагналаар хэзээ шагнагдсан:

№	Шагналын нэр	Хэдэн он

10. Шагнуулах гэж байгаа үндэслэл /Үндэслэлийг 5-6 өгүүлбэрт багтааж тодорхой бичнэ/

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

10. Ямар шагналаар шагуулах:

.....

.....

.....

.....

11. Хамт олны саналын хувь:

.....

.....

БАЙГУУЛЛАГЫН ДАРГА /ЗАХИРАЛ/ -ЫН ГАРЫН ҮСЭГ,
ТАМГА / ТЭМДЭГ